



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 18229

Улаанбаатар хот

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн байрны барилгын ажлын гүйцэтгэлтэй холбоотой арга хэмжээ авах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга	Д.Хатанбаатар	(Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга)
Гишүүд	Б.Хүсэлт	(Хууль, эрх зүй дүрмийн боловсруулалтын газрын ахлах мэргэжилтэн)
	Б.Амартүвшин	(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны дарга)
	Ч.Болдбаатар	(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын эдийн засагч)
	Ж.Билэгсайхан	(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн үйлчилгээ, дулаан сантехникийн албаны аж ахуй барилга засварын хэсгийн Барилгын ахлах инженер)
	Б.Бат-Эрдэнэ	(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн үйлчилгээ, дулаан

		сантехникийн албаны дэд дарга)
3.Туяа		(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын хууль, эрх зүй хариуцсан менежер)
П.Баатар		(Иргэний нисэхийн үндэсний төвийн Гэрэл суулт, цахилгаан хангалтын албаны дарга)
Ж.Ганбаатар		(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн үйлчилгээ дулаан сантехникийн албаны ерөнхий инженер)
Х.Рэнцэнпил		(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт захиалагчийн албаны инженер)
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхзул	(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын хуулийн мэргэжилтэн)

2.Барилгын гүйцэтгэл, ажлын явцад хяналт тавьж, гэрээний хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, барилгын ажлын явцын талаар сар бүр танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Хатанбаатар)-т үүрэг болгосугай.

3.Гэрээт ажлын явцад хөндлөнгийн хяналт хийлгэх, ашиглалтад хүлээн авахтай холбогдон гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар)-т зөвшөөрсүгэй.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/474 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН